

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2024/05/02 **Дуусах хугацаа:** 2024/05/19

Ажил эхлэх хугацаа: 2024/05 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын Засгийн газар болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН

/Түр ажлын байр/

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Багш, ажилтан, оюутны эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тандах, судлах, хянах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана.
- Сургуулийн хичээлийн байр, цайны газар болон оюутны дотуур байрны цэвэрлэгээ үйлчилгээ, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллана.
- Багш, ажилтан, оюутнуудад зориулан эрүүл мэндийн сургалт, семинар зохион байгуулж, эрүүл аюулгүй орчинд аж төрөх хэвшилд дадалжуулна.

Тавигдах шаардлага:

- Анагаах ухааны болон сувилахуйн чиглэлээр бакалаврын зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай;
- Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, соёл, дэг журмыг сахин ажиллах чадвартай байх;
- Мэдээлэл боловсруулах, судалгаа хийж дүгнэлт гаргах, баримт бичиг боловсруулж тайлан гаргах чадвартай байх;
- Компьютерын өргөн хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн байх;
- Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно;

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар /CV/
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та баримт бичгээ монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976 7023-2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.